



ТӨРИЙН ОРОН СУУЦНЫ КОРПОРАЦИ

ТӨРИЙН ӨМЧИТ ХЯЗГААРЛАГДМАЛ
ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ

Их тойруу 1, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15171

Утас/Факс: (976) 7288 7788,

Цахим шуудан: info@tosk.gov.mn,

Цахим хуудас: www.tosk.gov.mn

2026.08.17 № 01/926
танай _____-ны № _____-т

ГАМШГААС ХАМГААЛАХ БОЛОН
ГАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН
СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАГЧ
СУРГАЛТЫН ТӨВ, БАЙГУУЛЛАГА,
КОМПАНИУДАД

“Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК нь
Солонго-1, 2 төслийн нэгжийн инженер техникийн
ажилчдад **Гамшгаас хамгаалах болон Галын аюулгүй
байдлын** тухай сургалт зохион байгуулах гэж байгаа тул
2026.08.21-ний дотор хавсралтад заасны дагуу үнийн
санал бэлтгэн ирүүлж, хамтран ажиллахыг хүсье.

Хавсралтаар ажлын даалгавар хүргүүлж байна.
Хавсралт ... хуудастай.


ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.ЛХАГВА-ОЧИР



1525000518

“Төрийн орон сууцны корпораци”
ТӨХХК-ийн 2026 оны 08 сарын 17..
өдрийн 01/2026 дугаар албан бичгийн
хавсралт



**“ГАМШГААС ХАМГААЛАХ БОЛОН ГАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТУХАЙ НИЙТ АЖИЛЧДЫН
СУРГАЛТ” ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР**

1	Ажлын нэр	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нийт ажилчдын сургалт
2	Захиалагч	“Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК
3	Ажил гүйцэтгэх хугацаа	Гэрээ байгуулсан өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд гүйцэтгэнэ.
4	Үндэслэл	Гүйцэтгэх захирлын 2026.01.09-ний өдрийн А/06 тоот тушаалаар батлагдсан Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний 1 дүгээр хавсралтын 6.58-д тусгагдсан.
5	Хамрагдах ажилчдын тоо	38
6	Зорилго	Ажилчдад ХАБЭА-н мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлж, ажлын байрны осол, эрсдэлээс урьдчилан сэргийлэх чадварыг сайжруулахад оршино.
7	Хууль, стандартын үндэслэл	Сургалтыг дараах хууль, стандартын дагуу зохион байгуулна: • ХАБЭА-н тухай хууль • ХНХЯ сайдын А/130 дугаар тушаал • MNS 4969:2000 • БНБД 12-02-24
8	Ажлын хамрах хүрээ	Гүйцэтгэгч нь дараах ажлыг хэрэгжүүлнэ: 1. Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулж батлуулах 2. ХАБЭА-н сургалтыг батлагдсан хөтөлбөрийн дагуу зохион байгуулах 3. Сургалтын материал (гарын авлага, презентаци, тараах материал) бэлтгэх 4. Сургалтын явцыг баримтжуулах (гэрэл зураг, бүртгэл)

		5. Оролцогчдод сертификат олгох 6. Сургалтын үр дүнг үнэлэх
9	Сургалтын үндсэн агуулга	Сургалт нь дараах үндсэн сэдвүүдийг хамарна: • ХАБЭА-н хууль, эрх зүй • Ажлын байрны аюул, эрсдэлийн үнэлгээ • Барилгын ажлын аюулгүй ажиллагаа • Хувийн хамгаалах хэрэгслийн зөв хэрэглээ • Галын аюулгүй байдал • Осол, зөрчлийг мэдээлэх журам • Анхны тусламж
10	Тавигдах шаардлага	Байгууллага • ХАБЭА сургалт явуулах эрхтэй байх /гэрчилгээ/ • Ижил төрлийн сургалт зохион байгуулсан туршлагатай байх Сургагч багш • Мэргэжлийн үнэмлэх, сертификаттай байх • Сургалт явуулах туршлагатай байх
11	Сургалт зохион байгуулах ажлын үе шат	1. Сургалт зохион байгуулах ажлын даалгавар боловсруулж, батлуулах 2. Сургалтын байгууллагаас үнийн санал авах 3. Сонгон шалгаруулалт хийх 4. Хөтөлбөр батлуулах 5. Сургалт зохион байгуулах 6. Оролцогчдын бүртгэл баталгаажуулах 7. Сертификат олгох 8. Тайлан хүлээлгэн өгөх
12	Тайлагнал	Гүйцэтгэгч дараах баримт бичгийг хүлээлгэн өгнө: 1. Сургалтын тайлан 2. Оролцогчдын нэрсийн жагсаалт 3. Фото зураг 4. Сургалтын материал 5. Сертификатын хуулбар
13	Үр дүнгийн шалгуур	• Сургалт бүрэн зохион байгуулагдсан байх • Оролцогчдын ирц 90%-аас доошгүй байх • Бүх оролцогч сертификат авсан байх • Тайлан бүрэн ирүүлсэн байх